

АЗИ СУДЛАЛЫН ЭРДЭМТЭН КЛАУС ЗАГАСТЕР (*1933): ГЕРМАНЫ УЛС ТӨРИЙН ТҮҮХИЙН ДАВАЛГААН ДУНД ӨРНӨСӨН ТҮҮНИЙ АМЬДРАЛ, АЖИЛ ҮЙЛС

ИНЕС ШТОЛЬПЕ

Товч агуулга: Клаус Загастер өнөө үеийн Монгол ба Төвд судлалын томоохон төлөөлөгчдийн нэгэнд¹ зүй ёсоор тооцогддог нь дээд боловсролын салбартаа өндөр нэр хүндтэй, нөлөө бүхий багш төдийгүй тухайн хоёр салбараас хавьгүй хол давж сэтгэн, судалгааны бүтээлээ туурвидаг эрдэмтэн билээ. Бага залуугаасаа шашныг сонирхон судалж эхэлсэн нь түүнийг Европын тав, Азийн таван хэлийг сурч судлахад хөтлөөд зогсоогүй хэлний мэдлэг нь түүнд шашин, улс төр хоорондын холбоо хамаарлыг нилээд хэдэн чиглэлээр олон талаас нь задлан шинжлэх боломжийг нээсний зэрэгцээ түүх бичлэг, уран зохиол, бэлгэдэл зүй болон аливаа учир сэдлийн түүх зэрэг хоорондоо холбоо хамаарал бүхий судалгааны талбаруудад эх сурвалжил шүүмжлэлтэй бөгөөд нухацтай хандан, хам сэдэвт тулгуурлан нэвтрэх боломжийг ч олгожээ. Клаус Загастер *Histoire croisée*, *Transfargeschichte* юм уу *Entangled history* зэрэг (хүн төрөлхтний түүхийг улс үндэстэн бүрээр тус тусад нь салангид авч үзэх бус харин харилцан хамаарал, нөлөөлөлд нь судлах, орч.) концепц санааг нийтэд мэдэгдэхээс бүр өмнө олон үндэстэн, олон соёл хамарсан холбоо харилцаа, орчуулга болон аливаа үйлчлэл нөлөөллийн түүхийн сэдвүүдийг янз бүрийн өнцгөөс ажиглаж, судлан боловсруулахдаа олон ургалч үзлийн аргазүйг удирдлага болгосон байна. Мөн Германы түүхийн хамгийн харанхуй цаг үед төрж бойжсон түүний нэгэн үеийнхний хувьд гайхамшигтай нь Клаус Загастер харьцуулсан хэл шинжлэл ба уран зохиол болон дэлхийн түүхэнд баримжаалсан соёл судлалын ажлаа аль болох орчин цагийн хүмүүнлэгийн асуудлуудтай уялдуулан, тэр ч байтугай хүйтэн дайны цагт ч тэрхүү төмөр хөшгийг даван ард түмнүүдийн харилцан ойлголцлын төлөө бие сэтгэлээ зориулж байсанд оршдог билээ.

Түлхүүр үг: Монгол судлал, хүйтэн дайн, Зүүн болон Баруун Герман, Олон улсын Монгол судлалын холбоо, Walther Heissig

¹ Түүнд хүндэтгэл илэрхийлсэн бичвэр болон бүтээлийн жагсаалт дараах бүтээлүүдэд бий: Kollmar-Paulenz/Peter (2002) түүнчлэн Kollmar-Paulenz/Eimer (2013). Толиуулан буй энэ өгүүллэгт хэрэглэгдсэн монгол, орос үгсийг Фийтцегийн эрдэм шинжилгээний галигчлалын (Vietzel 1988) дагуу галигласан болно. Харин олон улсад түгээмэл өөр хэлбэрээр бичигддэг ухагдахуунууд, хүний болон газар усны нэрс нь үүнд хамаарахгүй.

Энэхүү өгүүлэл XX зуун, XXI зууны эхний жилүүдийн Германы улс төрийн донсолгоот түүхийн давалгаанд шударга тууштай ажиллаж ирсэн Ази судлалын энэ эрдэмтний² шинжлэх ухаанд зүтгэсэн түүхэн замналын талаарх өдийг хүртэл нийтэд мэдэгдээгүй үйл явдлуудад уншигчдын анхаарлыг хандуулах болно.

Клаус Загастер улс төрийн гурван өөрчлөлт хувьсал, нийгмийн дөрвөн өөр тогтолцоонд амьдарч яваа ч түүх-хэл шинжлэл давамгайлсан сургалт-судалгааныхаа ажлын хүрээнд хэзээ ч зөвхөн өнгөрсөн үеийг онцлон онилсон, амьдралаас тасархай бичгийн ширээний эрдэмтэн байгаагүй юм. Ямар ч өө сэвгүй, үнэнч шударга тууштай байх нь түүнд зарим тохиолдолд мэдээжийн хэрэг амаргүй байсан ч бие хүнийхээ хувьд амсаж туулсан улс төрийн хатуу чанга дарамт шахалт ч түүнийг улиг домог болсон ягшмал үзэл баримтлал бүхий үйл хөдлөлд уруу татаагүй. Харин ч судалгаагаа хийх бүс нутгууд болон өмнөх системийн зүүний орнууд руу аялан явах замдаа ч тэрбээр хэзээд бие биеэ харилцан хүндэтгэж, олон улс хоорондын эрх тэгш хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхийн төлөө сэтгэл зүтгэлээ зориулсаар иржээ. Ийм үзэл бодол, байр суурь, хандлагаараа тэрээр Ази судлалдахь өөрийн төлөөлдөг сургалт-судалгааны чиглэлийн нэр хүндийг өндөрт өргөсөн гавъяатай төдийгүй Монгол судлалын салбарын түүхэндэх хүйтэн дайны хор нөлөөллийг даван туулахад хамгийн ихийг хийж гүйцэтгэсэн нэгэн билээ. Бонны Монгол судлалыг анх үүсгэн байгуулахад Загастер ихээхэн хүчин чармайлт гаргаж байсан юм. Ер нь түүний мэргэн хэрсүү ухаан, хянамгай бодлого, дэлхийн шинжлэх ухаан дахь өндөр нэр хүнд, дипломат эв дүй, ур ухааны ачаар л Бонны Монгол судлал оноог хүртэл оршин тогтнож, үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байгаа билээ.

Ази судлалын ухааны тухайд:

Хүйтэн дайны бартаат замаар хийсэн холын зайн гүйлт

Клаус Загастер 1933 оны 3-р сард Умард Бөймегийн Ниймэст (чехээр: Mimon) төрж, хүүхэд насныхаа нэгээхэн хэсгийг Элба голын эрэг дээрх Ауссит (чехээр: Ústínad Labem) өнгөрөөжээ. Энэ л хотод тэрээр дэлхийн хоёрдугаар дайны үеэр амьдралдаа анх удаа монгол хүнтэй учирсан нь: 1944 онд спортын

² Энэ өгүүллийн зохиогч дурьдсан намтрын мэдээлэл, баримт бичиг болон гэрэл зургуудыг (хөрөг зургийг оруулахгүйгээр) Клаус Загастертай ихэнхдээ 2017 оны хавар Конигсвинтерт ярилцаж байхдаа түүний зөвшөөрлөөр ашигласан болно. Надад итгэж, монгол, германы түүхийн нийтэд хараахан танил бус хэсгүүдийн талаарх амьдралынхаа түүхийн сонирхолтой үйл явдлуудыг өгүүлсэнд би талархаж байна.

цэнгэлдэх хүрээлэнд болсон ядуучуудад “өвлийг давахад нь туслах”³ зорилготой мөнгө, хувцас цуглуулах арга хэмжээний үеэр тэгэхэд арван нэгэн настай байсан хүү бусдаас ондоо зүс царайтай хоёр цэрэгтэй уулзахад тэд түүнд маш нөхөрсөг хандан, тухайн үедээ харьцангуй өндөр ханштай нэг райхсмарк хандивлаж байжээ. Клаус Загастер цэргүүдийн гарын боолтон дээрх “Kalmücke” (Халимаг гэсэн герман үг, орч.) хэмээх үгийг уншиж амжсан ч тэд үнэндээ хэн⁴ болохыг мэдэлгүй маш их гайхсан байна. Загастер тэр үед энэ хоёр цэрэг монгол хүмүүс байсныг, 1951 оноос эхлэн АНУ-руу цагаачлан гарсан халимагуудтай төвдөөс улбаалсан монголын бурхны шашныг судлах явцдаа гучин жилийн дараа дахин уулзана гэдгээ мэдээжийн хэрэг төсөөлөөгүй явжээ. Дэлхийн хоёрдугаар дайн түүнийг эхлээд тэс өөр газар луу явахад хүргэсэн байна. 1938 онд нацист Германуудын эзлэн авсан Сүдетенландын нэг хэсэг болох Умард Бөймегийн герман хэлтэн зонхилсон нутгуудыг 1945 онд Чехословакт эргэж нийлүүлэн, тэнд оршин сууж байсан германуудын ихэнх хэсгийг хөөж гаргахад Загастерынхан Коттбусын (хуучин ардчилсан германы хот, орч.) ойролцоох Глинцигт амь зуух болжээ. Эцэг, эх нь шинэ нутагтаа бага зэрэг төвхнөсний дараа Клаус Загастер Коттбусын эв нэгдлийн ахлах сургуулийн эртний сонгодог хэлний ангид элсэн орж суралцаад, 1951 онд шалгалтаа өгч сургуулиа төгсчээ.

³ *Das Winterhilfswerk des Deutschen Volkes* буюу *Германы ард түмний өвөлд туслах үйл хэрэг* гэдэг нь нацист германы үед тусламж шаардлагатай буюу ардын нөхөд хэмээн нэрлэгдэж байсан ядуучуудад мөнгөн болон эд материалын хандив өргөх олон нийтийн өргөн хэсгийг хамруулсан сангийн нэр юм. Үүний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Tennstedt (1987)-д үзнэ үү.

⁴ Халимагууд (германаар: Die Kalmücken, оросоор: калмыки) нь 17-р зуунаас эхлэн Хаант Орос Улсын үед голдуу Ижил Мөрний доод биеэр цагаан хааны албат болон амьдарч байсан баруун монголын Ойрадуудын нэг хэсэг мон. Тэд Зөвлөлт засгийн эхний жилүүдэд Сталины засаглалын үед хүчээр хамтралжуулахын эсрэг тэмцэж, 1942 оны зун германы Вермахтын холбоотнууд Халимагийн БН Автономит улс руу (1935-42 онд) довтлон орсны дараа хэдэн мянган халимагууд тэдний удирдлагад нэгдсэн байна. 1942 оны 12-р сард улаан арми тэрхүү бүс нутгийг эргүүлэн эзэлж авсны дараа тэдний ихэнх нь халимагийн морин цэргийн корпус Вермахтын талд байлдаж, 1943 онд тэдэнтэй хамт буцаж, нэг хэсэг нь Элба мөрний эрэг дээрх Ауссигт ирсэн нь илэрхий байна. Энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Hoffmann (1974)-ээс үзнэ үү. Мон Вермахтын холбоотон халимагуудын талаар Veremej (2004), online: <https://www.freitag.de/autoren/der-freitag/eine-karawanserei> -аас үзнэ үү.



Зураг 1: Клаус Загастер (дунд эгнээнд, баруун гар талаасаа 3 дахь нь) Коттбусын сургуулийг хамт тогссон ангийнхныхаа хамт

Уг нь тэрээр эмч болох санаатай байсан боловч бүр тэр л үед дэлхийн олон шашны түүхийг маш их сонирхож эхэлжээ. Гимназийн нэг багш нь Хятадын түүхийн талаар богино илтгэл бэлтгэх даалгавар өгөхөд Клаус Загастер гараа өргөн гүйцэтгэхээр болж, Эдуард Эркесийн⁵ эмхэтгэн, ахлах сургуулийн түүхийн хичээлд зориулан 1948 онд хэвлүүлсэн сурах бичгийг шимтэн судлах болсон байна. Доогуур нь онцлон зурсан, хуудасны захад хийсэн тэмдэглэгээ зэргээс түүний сонирхол, хожмын судалгааны салбарууд аль тэгэхэд л дурайн харагдана, “Буддизмын сургаал нэвтрэн орж ирсэн”-ийг Эркес 18-р хуудсанд “weltflüchtige Metaphysik” буюу ертөнцөөс тасархай, амьдралд харш метафизик хэмээн тодорхойлсон, мөн 23-26-р хуудсан дахь монголчуудын тухай өгүүлсэн хэсгүүд Загастерын анхаарлыг ихээхэн татаж байжээ.

⁵ Хятад судлаач, угсаатны зүйч Эдуард Эркес (1891-1958) Бонн болон Лайпцигт суралцан, 1947 оноос Лайпцигийн Зүүн Азийн Хэл Шинжлэлийн Институтэд профессор байсан билээ.

Klaus Sagaster

LEHRHEFTE FÜR DEN GESCHICHTSUNTERRICHT
IN DER OBERSCHULE
SONDERHEFT

PROF. DR. EDUARD ERKES

DIE GESCHICHTE CHINAS



UND WISSEN VERLAGS GMBH · BERLIN/LEIPZIG

1948

Зураг 2: "Хятадын түүх" сурах бичгийн Загастерын
гарын үсэг бүхий хавтас

und die geographischen Kenntnisse der Chinesen reichten infolge der Beziehungen zu den Arabern bis über das Mittelmeer nach Sizilien und dem maurischen Spanien, dessen Fahrzeuge in den chinesischen Häfen wohlbekannte Erscheinungen waren.

Aber trotz der ökonomischen und kulturellen Blüte, die die Sung-Zeit heraufführte, war China politisch von Anfang an in sehr schwieriger Lage. Es gelang nicht, die Kitan aus Nordchina zu verdrängen, und vollends verhängnisvoll wurde es, daß China mit dem tungusischen Stamm der Dschurdschen, der im 11. Jahrhundert aus der Mandchurei nach China eindrang, sich im Nordosten festsetzte und 1115 eine eigene Dynastie Tchin begründete, ein Bündnis gegen die Kitan abschloß. Wohl brach das Reich der Kitan 1123 unter dem vereinten Ansturm der Chinesen und Dschurdschen zusammen; aber die Sieger wurden gleich selbst uneins, und 1125 fielen die Tchin bereits in China ein, eroberten einen großen Teil des Nordostens mit der Hauptstadt K'aifeng und führten den Kaiser samt der ganzen Regierung in Gefangenschaft. Doch wurde ihrem weiteren Vordringen so entschlossener Widerstand geleistet, daß sie darauf verzichteten und es zuließen, daß ein Angehöriger des Kaiserhauses eine neue Dynastie, die Südliche Sung (1127 bis 1279) begründete. Diese verlegte ihren Sitz von dem gefährdeten K'aifeng nach Hangtschou, das nun der Mittelpunkt der ostasiatischen Kulturwelt wurde. Der Krieg gegen die Dschurdschen wurde mit wechselndem Glück noch über ein Jahrhundert lang fortgeführt, bis sich für beide Gegner ein gefährlicherer Feind erhob, die Mongolen.

Die Mongolen, deren Name schon im 2. vorchr. Jahrhundert in der chinesischen Literatur auftaucht, treten erst um die Mitte des 12. nachchr. Jahrhunderts in die Geschichte ein. Aus Ursachen, über die nur Vermutungen möglich sind, entfalteten diese bis dahin fast unbekannten Stämme plötzlich eine märchenhaft anmutende Tatkraft, die sie binnen weniger Jahrzehnte, freilich nicht für allzulange, zu Herren der halben Welt machte. Wie immer in derartigen Fällen dürfte Nahrungsmangel das treibende Motiv gewesen sein; er zwang zu gemeinsamem Handeln und ermöglichte es politisch begabten Persönlichkeiten, größere Stammesverbände zu einen, militärisch zu organisieren und gegen die ackerbautreibenden Nachbargebiete zu führen. Hier fanden dann die Eroberer nicht nur reiche Hilfsquellen, sondern auch willige Helfer, die die Erfahrungen alter Kultur in ihre Dienste stellten und es ihnen ermöglichten, die eingeschlagene Bahn erfolgreich zu verfolgen. 1206 wurde auf einer Versammlung der mongolischen Stammesfürsten Temudschin, der spätere Dschingis Khan, zum gemeinsamen Führer aller Mongolen gewählt und begann alsbald Feldzüge gegen die umwohnenden Völker zu organisieren. Sehr wesentliche Unterstützung fand er bei seinem

23

Зураг 3: Монголчуудын тухай бичвэрт Загастерын доогуур нь зурсан тэмдэглэл бүхий 23 дахь хуудас

Уншсан зүйлдээ сэтгэл нь хөдөлсөн тэрбээр Ванг Тунг-куи, АнЛи-миннарын хоёр хятад хүнд англи хэлээр захидал бичиж эхэлжээ. Тэдний 1950 оны эцсээр Бээжинд гараар бичсэн нэгэн хариу захидалыг үзэхэд дэлхийн хоёрдугаар дайны дараах үеийн зүүн Азийн түүх болон хүйтэн дайны эхэн үе мөн түүнчлэн өнөөг хүртэл шийдвэрлэгдээгүй Солонгосын хойгийн зөрчлийн талаар сонирхолтой сэтгэгдэл төрүүлнэ:

“Эрхэм Клаус: таны захиаг бид хүлээн авлаа. Гэвч хоёр дахь захиаг чинь авах үед маш их завгүй байсан учир тэр дороо хариу бичиж чадсангүй, учир нь энд нэг мундаг том хөдөлгөөн гарч эхлээд байна. Энэ хөдөлгөөн “Америкийг эсэргүүцэн, Солонгосыг дэмжин, улсыг хамгаалах зорилготой. {...} Америкийн империалистууд манай хөрш Солонгосыг, мөн манай Тайваныг түрэмгийлэн, Умард, Зүүн Хятадын хот тосгодыг бөмбөгдсөн. Тэд манай орныг эзлэхийг санаархаж байгаа ч бид үүнийг тэвчиж чадахгүй, бид империалистуудын эсрэг зогсох ёстой. {...} Одоо бид одоо зөвхөн сургууль хичээлдээ яваад завгүй байгаа бус Солонгосын Ардын Арми болон Хятадын Ардын Сайн дурынхны агуу ялалт мөн шинэ жилийн баяр тэмдэглэх гээд ажил ихтэй хэвээр байна. Танд шинэ жилийн мэнд хүргэе!”⁶

Гэвч ахлах сургуулиа саяхан төгссөн Клаус Загастерын хувьд Хятадыг судлах сонирхол нь арай өөр асуудалд чиглэж байсан бөгөөд тэрээр Хятад судлалаар суралцах боломжийн талаар лавласан захиагаа чухам энэ үед Халле-Виттенбергийн Мартин-Лүтерийн Их Сургууль, Берлиний Хумболдтын Их Сургууль болон Лайпциг хотын Их Сургуулиуд руу аль хэдийн илгээж амжсан байлаа. 1950 оны арван нэгдүгээр сард Загастер Лайпцигийн Их Сургуулийн Философийн факултетийн деканы нэрийн өмнөөс бичсэн захиаг хүлээн авахад философ-түүхийн салбарт суралцах боломжтой бүхий л мэргэжлийн хичээлийн талаар мэдээлэл өгөөд зогсоогүй профессор доктор Эркес Хятад судлалын сургалтыг удирдан явуулж буйг дурьдсан байна.

DER DEKAN
DER PHILOSOPHISCHEN FAKULTÄT
DER UNIVERSITÄT LEIPZIG

LEIPZIG C 1, den 16. Nov. 1950
Ritterstraße 16-22 — Fernruf 35197

Herrn
Klaus Segester
Glinzing 13b bei Cottbus

In Beantwortung Ihres Schreibens vom 14. Nov. 1950 teilt die Philosophische Fakultät mit, daß an der philologisch-historischen Abteilung folgende Fächer gelehrt werden: Anglistik, Archäologie, Germanistik, Geschichte, Kunstgeschichte, Musikwissenschaft, Orientalistik, klassische Philologie, Philosophie, Psychologie, Religionsgeschichte, Romanistik, Slavistik, Soziologie, Ethnologie, vergleichende Sprachwissenschaften, Indologie, Sinologie, Japanistik. An der Universität Leipzig lehrt Herr Prof. Dr. E r k e s Sinologie.



Зураг 4: Лайпцигийн Их Сургуулийн Философийн факултетийн деканы мэдээлэл

⁶ Уг захианд нэгэн хөрөг зургийг хавсаргасан нь ар талд нь бичсэнээр „Commander-in-chief Chu Le“-гийн зураг юм (Клаус Загастерын хувийн архиваас). БНАГУ-ын дунд сургуулиудад тодорхой хэдэн “ах дүүгийн найрамдалт ард түмнүүд” хоорондоо захидлаар холбогдон харилцахыг дэмжих ажил 1980-аад оны эцэс хүртэл үргэлжилж байсан юм.

Ийнхүү мөнөөх Хятадын түүхийн сурах бичгийг зохиогч Лайпцигт амьдарч буйг мэдэж авсан Клаус Загастер шууд түүнд хандан захидал бичихэд Эдуард Эркес гарын үсгээ зурсан хариу захидалдаа тухайн мэргэжлийн чиглэлээр суралцах сонирхолтой залууд дараах зүйлийг бичсэн байна:

“... Хятад судлалын чиглэлээр суралцвал их сургуулийн багш, туслах багш болох зорилгоор эрдэм шинжилгээ судалгааны ажил хийх боломжтойн дээр номын санч, гадаад хэлний болон оройн дээд сургуульд багшлах, хэлмэрч - орчуулагч, сэтгүүлч, дипломат, хэрэв нэн ялангуяа Герман-Хятадын найрамдлын нийгэмлэг үндэслэн байгуулагдчихвал соёлын ажилтан зэрэг маш олон мэргэжлээр ажиллах үүд хаалга нээгдэнэ. Хэрэв хятад хэлээр шалгалт өгөх, мөн энэ хэлний чиглэлээр докторын ажил бичье гэвэл философийн факультетийн бусад бүх мэргэжлийн хичээлтэй, мөн япон хэл, шашны түүхийн хичээлтэй ч уялдуулан суралцах боломжтой. Таныг гүнээ хүндэтгэсэн Эдуард Эркес.”⁷

Захиаг аваад Клаус Загастер хөл нь газар хүрэхгүй шахам баярлан хөөрч, тэр даруй Лайпциг руу хөдөлжээ. Зорьсон газраа ирээд, эхлээд Эркесийн гэрийн хаягаар профессорын үүдэнд очсон ч гагцхүү уулзалтын цагаарирэх хэрэгтэй болсон байна. Ингээд Клаус Загастер 1951 онд Хятад судлалаар сурч эхэлжээ. Түүнийг суралцаж байх үед профессор Эркесийн түүхийн хичээлийн (тэр үед бичгийн машинаар хувилсан) лекцүүд төдийгүй эртний хятадын уран зохиол бүтээлүүдийг бүхлээр нь уншиж, тайлбарлаж өгдөг байсан нь сонсогчлод тухайн ном зохиолтой бүрэн хэмжээгээр нь танилцах боломжийг олгодог байсан зэргийг одоо тэрээр онцгой тод дурсан санаж байлаа. Үүний зэрэгцээ герман, оросын хэл, уран зохиолын болон биеийн тамирын хичээлүүдэд зайлшгүй суух шаардлагатай байсан бөгөөд бусад хичээлийг бодоход биеийн тамирын хичээлд энэ оюутан тогтмол оролцож байгаагүй нь нэг тодорхойлолтоос нь харагдаж байлаа.⁸

Лайпцигийн Дорно Дахин судлалын маш өргөн хүрээтэй, анхаарал татахуйц сургалтын хөтөлбөрөөс Клаус Загастер өөр бусад хичээлийг ч илүү түлхүү сонирхож байлаа. Гэвч Фридрих Веллерийн удирдлаганд Энэтхэг судлалыг үндсэн хичээл болгож судлах түүний хүслийг Эркес нэг их ойшоогоогүй учир тэрээр

⁷ 1951 оны 1-р сарын 12-нд бичсэн захианы эхний мөрөнд: “Лайпцигийн Их Сургуулийн Зүүн Азийн Семинар” мөн Эркесийн хаяг “Лайпциг В 5, Ратхэнауштрассе 23” гэж бичсэн байв (КлаусЗагастерын хувийн архиваас).

⁸ Лайпцигийн Их Сургуулийн оюутны хичээлд суусныг гэрчлэх баримт (КлаусЗагастерын хувийн архиваас).

тухайн үед монгол хэл зааж байсан Паул Рачневскитэй⁹ ярилцжээ. Хожмын “Зүүн Германы гарамгай монгол судлаач”¹⁰ ухаалгаар инээмсэглэн, түүнд мэргэжлийн чиглэлээ солих нь тухайн асуудлыг шийдвэрлэж болох нэг гарц мөн хэмээн санал болгожээ. Ийнхүү Клаус Загастерын зохих өргөдөл хүсэлтийг 1953 оны 5-р сард наашгайгаар шийдсэн байна.

Herrn stud.phil.Klaus Saegaster, Leipzig.

Betr.: Fachrichtungswechsel.

Wir geben Ihnen davon Kenntnis, dass der von Ihnen beantragte Fachrichtungswechsel von Sinologie zur Mongolistik ohne Studienverlängerung genehmigt worden ist.

Lauftrage:

Kölbel
(Kölbel)

Referent

Leipzig, den 27.5.53.
K.

Зураг 5: Хятад судлалыг Монгол судлал болгон мэргэжлийн чиглэлээ солихыг зөвшөөрсөн бичиг

Клаус Загастер Энэтхэг, Монгол судлалд соёл болон оюун санааны түүхийн хувьд ойр дотийг нь бодож, Ёоханнес Шүбертийн удирдлаганд мөн Төвд судлалаар суралцжээ.¹¹

Ийнхүү Лайпцигийн Дорно дахины судлал оюутан хүүд дээд боловсролын салбарт эрдэм шинжилгээний ажил хийх сайхан боломжуудыг олгож байсан бол

⁹ Хятад ба Монгол судлалын бүтээлээрээ нэрд гарсан Паул Рачневски (1899-1991) нь францын хятад ба төв ази судлаач Паул Пеллиотийн (1878-1945) шавь байсан юм. Рачневски Берлиний Фридрих-Вилхельмийн Их Сургууль болон Парисын Сорбонны Их Сургуульд философи, дорно дахины хэл түүнчлэн орос, герман хэл судлалаар суралцсан бөгөөд 1953 онд Лайпцигт монгол хэлний сургалт хариуцсан профессороор уригдан ажиллаж, тухайн жилдээ Берлиний Хумболдтын Их Сургуульд шилжин 1964 онд гавьяаныхаа амралтанд суугаа Хятад-Монгол судлалын тэнхимийг удирдаж байсан юм.

¹⁰ Barkmann (1994), номын гарчиг.

¹¹ Ёоханнес Шүберт (1896-1976), тэрбээр 1960-1962 онд Лайпцигийн Их Сургуульд Төвд судлалын тэнхимийг удирдан ажиллаж байсан, өмнө нь эхлээд философи, шашин судлалаар суралцсан бөгөөд санхүүгийн гачигдлын улмаас хичээлээ түр завсарлаад, дараа нь Дорно дахины судлал руу шилжин суралцсан байна. Хожим тэрбээр Төвд судлалын зэрэгцээ Хятад, Манж, Монгол болон Түрэг судлалаар суралцжээ.

(БНАГУ - Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улсын буюу коммунист засаглалтай байсан хуучин Зүүн Герман Улсын, орч.) Дотоод Яамныхан (Stasi) түүнийг хавчин дарамталж эхэлснээр амьдралд нь хүйтэн дайны сүүдэр гэнэт хойт хаалгаар түрэмгийлэн орж ирсэн байна. Элба мөрний эргийн Ауссиг хотод танилцаж, дараа нь Лайпцигт дахин уулзсан түүний нэг найз залуу Баруун Берлин рүү явж ороод, буцаж ирсэнгүй. Дотоод Яамныхан Клаус Загастераас найзыгаа БНАГУ-д буцааж авчрахыг шаардаж, хэрэв ингэвэл найз нь “энх тайван, ардчиллын замдаа эргэж орох болно” хэмээн өгүүлсэн байна. Энэхүү тулган шаардалтаас зайлах аргагүй тул Клаус Загастер die Stasi (тэр үеийн БНАГУ-ын Дотоод Яамныхан энэ товч нэрээрээ бүхэнд танил байв, орч.) буюу Дотоод Яамныхан хараандаа авсан болохыг найздаа хэлж анхааруулах зорилгоор Баруун Берлин рүү явжээ. Савхин дээлтэй ноёд Загастерыг мөрдөн уулзах бүрт зугтаан гарсан нөхрөө ятган, буцааж ирүүлэх ажил “харамсалтай нь” хараахан бүтэлтэй болоогүй байгааг дуулгах нь зүйтэй хэмээн цаг хожиж, үйл явцыг удаашруулах тактикийг хоёр найз боловсруулан тохиролцжээ. Сэтгэл зовоосон иймэрхүү асуулга бүр олшроход Загастер Коттбус хотын католик сүмийн туслах лам, ромын католикийн нэгэн санваартанд итгэн нууцаа дэлгэжээ. Хожим нь Дрезден – Майссен хотын хамба лам, Зүүн Германы хамба лам нарын бага хурлын тэргүүн болсон Герхард Шафран дурьдсан ээдрээт нөхцөл байдалд “нууцаар сөрөн удирдах офицер мэт” сэтгэн, шахаанд орсон оюутан залууд “гүн сүсэгт католик шашинтны дүр үзүүлэн”, Дотоод Яамныхны үүрэг даалгаврыг “ёс зүйн учир шалтгаанаар” гүйцэтгэх боломжгүй байгааг тэдэнд байнга хэлж байхыг зөвлөсөн байна. Гэвч die Stasi буюу Дотоод Яамныхан асуудлыг зүгээр орхисонгүй: жил хагасын дараа савхин дээлтэй хоёр ноён дахин ирж, илэрхий сүрдүүлсэн дуугаар “Та биднийг хуурч байна. Бид танд дахин хоёр долоо хоногийн хугацаа өгье, тэгээд юу болохыг та хараарай” хэмээн хэлжээ.

Клаус Загастер уг нь баруун руу дүрвэн гарах санаагүй байсан хэдий ч дээрх гай зовлон ёрлосон мэдэгдлийг сонсоод, хий хоосон сайхан зүйл мөрөөдсөнгүй, тэдний зүгээс өгсөн сүүлчийн хугацааг ч хүлээснгүй. Тэрээр 1954 оны гурван сард 20 насандаа БНАГУ-ыг орхин гарчээ. Энэ алхмыг хийх үедээ 1948 онд Берлинд хэвлэгдсэн Дорно дахины гарын авлага ном дахь Бертолд Шпулерийн “Монголчуудын эрин үе” хэмээх өгүүллийг дотуур хувцсандаа нуугаад авч гарсан нь түүний ганц дагуул болж байлаа. Клаус Загастер Баруун Берлин рүү орох хот доторх хэсгүүдийн зааг хязгаарыг цахилгаан тэргээр туулан гарахад түүнд нэгэн цагдаа 1953 оноос эхлэн тус хотын Марийнфелд дүүрэгт дүрвэн гарагч

болон зугтан ирэгсдийг шуурхай хүлээн авч байсан байранд очихыг зөвлөсөн байна. Тэнд түүнийг барууны холбоотнуудын бүрэн эрхт төлөөлөгчид бүгд тус туслаа байцаажээ. АНУ-ын төлөөлөгч Загастераас Лайпцигийн орчин тойронд цэрэг хуралдаж буйг анзаарсан эсэхийг асуусан бол нилээн хүйтэн хөндий харьцаатай франц сурвалжлагч бүсгүй (FDJ буюу тэр үеийн Зүүн Германы Чөлөөт Залуучуудын байгууллага, орч.) залуучуудын гишүүнийх нь үнэмлэхийг хураан авч, харин нэгэн англи эр дэндүү олон юм шалгаасан ч эцэстээ жинхэнэ соёлтой эр хүний зангаар тэр үед 20 настай байсан залууг сайныг хүсэж зоригжуулсан байдлаар үүд хүртэл үдэж өгч байсан гэдэг.

Загастерыг дараа нь Германы Оюутны Холбоонд очиход дөнгөж ирсэн түүнээс одоо яах санаатай байгааг нь асуужээ. Хил давж ирээд бүх зүйл өөрийн толгой дээр буусан Клаус Загастер юуны түрүүнд амь зуух бага сага мөнгө олох ёстой хэмээн хариулсан байна. Хичээл сургуулиа үргэлжлүүлэхийг хүсэхгүй байгаа юмуу гэсэн асуултанд тэрээр мэдээж ингэхийг хүсэлгүй яахав, тэгэхдээ Гёттингенд гэжээ. Учир нь тэрээр өмнө нь Лайпциг дахь Deutsche Bücherei буюу Германы Номын Санд сууж байхдаа тэндхийн Их Сургуульд Хятад, Монгол судлал ч, Төвд судлалын ч хичээлүүд заадаг болохыг олж мэдсэн байна. Гэтэл оюутны холбооныхон түүнээс сургуульд элсэх маягт материалуудыг даруйхан бөглөхийг хүсэж, мөн дүрвэгч хэмээн албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн хүмүүст хүртээдэг мөнгийг цалин хөлсийг тэнцвэржүүлэх хуулийн дагуу олгоххүртэл хүрэлцэх сургалтын тэтгэлэг өгөх болно хэмээн хэлэхэд тэрээр ихэд гайхжээ. Гэхдээ Клаус Загастер цаашдын ажил үйлдээ анхаарлаа хандуулахаасаа өмнө аргагүйн эрхэнд орхин гарсан ойр дотны чухал хүмүүстээ бүгдэд нь захиа илгээжээ. Хамгийн түрүүнд мэдээж эцэг, эхдээ,¹² дараа нь Лайпцигийн Их Сургуулийн багш нартаа ч бүгдэд нь бичсэн байна. Тэдгээр хүмүүст тэрээр зөвхөн хийсэн энэ алхмынхаа талаар мэдээлээд зогсоогүй баярласан талархсан сэтгэлээ илэрхийлээд, тэр ч байтугай номын сангаас зээлж авсан номнуудаа эргүүлж өгөх ажлыг ч зохион байгуулсан байна. Тухайн үеийн нөхцөл байдалд захиандаа хариу авна гэж хүлээхэд хэцүү байсан хэдий ч тэрбээр зөвхөн Египет ба шашин судлаач эрдэмтэн Зигфрид Моренцоос¹³ л захидал авчээ.

¹² Загастер эцэг, эхтэйгээ бүр хожуу дахин уулзжээ. Мөн тэр жилдээ тэрбээр умард хэсэг нь зөвлөлтийнхөд эзлэгдсэн байсан Австрийн Линц хотод очиж хамаатан садангуудтайгаа уулзсан байна. АНУ-ын эзэмшилд байсан өмнөд нутгаас Дунай мөрнийг гэтлэн явж байх завшаанаа ашиглан гадаад хэл дээрх олон ном бүхий олон улсын номын сангаас орос хэлээр мэргэжлийн ном худалдаж авч байжээ.

¹³ Зигфрид Моренц (1914-1970) нь Лайпцигт дэд докторын зэрэг хамгаалсан бөгөөд 2009 оноос Бонны Их Сургуулийн Египет судлалын профессороор ажиллаж буй Людвиг Давид Моренцийн эцэг юм.

Аденауерын эринд (дэлхийн хоёрдугаар дайны дараах Баруун Германы анхны ерөнхийлөгчөөр Конрад Аденауерын ажиллаж байсан жилүүд, орч.) дөнгөж ирсэн оюутныг ямар ч хүнд сурталгүй, юуны өмнө хугацаа алдалгүйгээр тэр дор нь Баруун Германы шинжлэх ухааны байгууллагатай холбон өгч байсан нь гайхамшигтай санагдаж байна: 1954 оны 3-р сарын 15-нд Клаус Загастер Гёттингенд ирж, мөн оныхоо 5-р сарын 2-н гэхэд л Георг – Августийн нэрэмжит энэ их сургуульд хичээл сургуулиа үргэлжлүүлэх боломжтой болсон байна. Мөн энд л эцэст нь Энэтхэг судлалыг туслах хичээлээр сонгон, Эрнст Валдшмидтийн¹⁴ удирдлаганд суралцах болжээ. Тэр үед Гёттингенд монголын уран зохиолын түүхийг зааж байсан Вальтер Хайсиг¹⁵ Копенгагены Их Сургуульд суралцах тэтгэлэгт өрсөлдөхийг Клаус Загастерт зөвлөжээ. Тэнд тэрээр 1956 оны намраас түрэг, монгол судлаач Кааре Грөнбэхийн удирдлаганд суралцах ёстой байсан ч эрдэмтэн хүнд өвчтэй байж, тун удалгүй 1957 оны эхээр насан эцэслэжээ. Клаус Загастер Копенгагенд хоёр семестр суралцахдаа 1956– 57 онд Грөнбэхийн туслах Кааре Томсен Ханзенаар монгол, эртний түрэг хэл заалган, Эрик Хаарын хичээлд сууж төвд хэлнийхээ мэдлэгийг гүнзгийрүүлсэн байна. Үүний зэрэгцээ тэрээр тухайн үед эрдмийн сургуульд герман хэлтэн сонсогчдод анх удаа зааж эхэлсэн дани хэлний курст ч сураад авчээ. Ийнхүү дани хэлний мэдлэгээ тэрээр хичээл сургалтын үеэр багш нар герман хэлээр тайлбарлахаас өөр аргагүй болдог байсан үед ч, амьдран сууж байсан айлынхаа эзэгтэй болон түүний гэр бүлийнхэнтэй харилцахдаа ч өдөр тутмын амьдралдаа хэрэглэж чаддаг байжээ. Дашрамд өгүүлэхэд энэ гэр бүлтэй тэрээр тавь гаруй жилийн турш нөхөрсөг харилцаатай байж ирсэн байна. Өмнө нь Вальтер Хайсиг, Чарльз Баудены¹⁶ хамт каталогижуулсан, харин хараахан судалж боловсруулаагүй байсан монгол гар бичмэл материалуудын цуглуулга бичвэрүүд Копенгаген дахь Эзэн Хааны Номын

¹⁴ Эрнст Валдшмидт (1897-1985) нь 1936 оноос Гёттингенд Энэтхэг судлалын профессор байсан. Тэрбээр Турфан судлалд оруулсан хувь нэмрээрээ алдартай болсон билээ.

¹⁵ Вальтер Хайсиг (1913-2005) Вена, Берлин хотод Хятад судлал, эртний түүх, угсаатны зүй, түүхэн газарзүй болон Монгол судлалаар суралцсан бөгөөд 1941 онд Венад дэд эрдэмтний зэрэг хамгаалсан. 1940-өөд оны эхний хагаст тэрбээр Бээжингийн католик шашны Фү-Жэн Их Сургуульд ажиллаж байсан бөгөөд Өвөр Монгол болон Манжуур луу маш олон удаа аялсан байна. Дайн дуусахад тагнуулч хэмээн сэрдэгдсэнээс үүдэн Хятадаас гарч яваад, 1951 онд Гёттингенд шинжлэх ухааны докторын зэргээ хамгаалж, 1957 онд Бонн руу шилжин, 1964 онд Их Сургуулийн орон тооны профессор, Төв Ази Судлалын Семинарыг үндэслэн байгуулагчийн хувьд энэ тэнхимийг удирдан ажиллах болжээ. Вальтер Хайсигийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Walravens (2012) бүтээлээс үзнэ үү.

¹⁶ Чарльз Роскелли Бауден (1924-2016) нь 1955-аас 1984 хүртэл Лондоны School of Oriental and African Studies (SOAS) - Дорно дахин, Африк судлалын Институтэд Монгол судлалын профессороор ажиллаж байсан.

Санд байсныг уншиж судлахад Загастер цаг заваа зориулдаг байв. Докторын судалгааны ажлын төсөлдөө тэрбээр 17-р зууны улс төр-шашны гол төлөөлөгч гэж тооцогддог байсан Бээжингийн нэгдүгээр Жанжаа буюу Зангиа Хутагтын намтрыг монгол хэлнээс орчуулжээ.

Энэ завсар Вальтер Хайссиг Гёттингенээс Бонн руу шилжсэн байсан тул Клаус Загастер Копенгагенаас шууд мөн л тийшээ очиж, үндсэн хичээл Хятад судлал болон Монгол ба Энэтхэг судлалаар докторын зэрэг хамгаалжээ. Тэрбээр 1959 онд Бонны Их Сургуулийн Евангел-шашин Судлалын Факультетийн деканы ажлын өрөөнд болсон энэхүү шалгалтанд шууд гурван хэл судлалаар мэдлэгээ сорьжээ: эхний шалгагч Вальтер Хайссиг түүнтэй ярилцлага хийж шалгасны дараа залгуулаад Хятад судлаач Петер Ольбрихт¹⁷ тухайн таатай уур амьсгал дунд Хятад судлалыг хөндлөн гулд хамарсан олон тооны асуулт тавьсан байна. Эцэст нь Энэтхэг судлаач Паул Хакер оюутан залуугаас агуулгын чанартай хэдэн зүйл асуухаасаа өмнө санскрит хэл дээр бичсэн дөрвөн хуудас бичвэрийг шууд орчуулах даалгавар өгч гүйцэтгүүлсэн байна.


Дэд докторын зэргээ хамгаалсны дараа Клаус Загастер монгол гар бичмэл материалуудын каталог болон монголын газрын зургуудыг судлан боловсруулах ажилдаа зориулан Германы Судалгааны Нийгэмлэгийн тэтгэлэг хүртсэн байна. Эцэст нь 1964 онд Бонн хотын Их Сургуульд Вальтер Хайссигийн удирдлагаар Төв Азийн Хэл Соёл Судлалын Семинар¹⁸ Монгол ба Төвд судлалын чиглэлээр үндэслэн байгуулагдахад хоёр туслах багшийн¹⁹ нэгээр ажиллах болжээ. Уг Семинар Кобленцийн Хаалганы дээд хэсэгт байрлан, орох хаалгыг нь Төвд, Монгол дахь Буддын дуганы хэв маягаар чимэглэсэн байна. Төв Ази судлалын мэргэжлийн номын санг Пруссийн Улсын Номын Сангийн Соёлын Өв Сан болон Копенгаген дахь Эзэн Хааны Номын Санд хадгалагддаг монгол гар бичмэл, Blockdruck буюу боловсруулаагүй материалууд бүхий арвин баялаг цуглуулгын фото хуулбаруудыг оруулаад байгуулж эхэлсэн байна. Вальтер Хайссигийн “Та төвд хэлийг хариуцна!” гэсэн тушаал нь Боннд Загастерын ажлын эхний голлох талбар болжээ. Бонны Их Сургуулийн философийн факультетийн хүндэт доктор монгол ба Алтай судлаач Николаус Поппе, Лхаст ажиллаж байсан Их Британийн

¹⁷ Петер Ольбрихт 1956 оноос Бонны Их Сургуулийн Дорно дахины Судлалын Семинарын Хятад судлалын салбарын эрхлэгч, 1963-1975 онд Хятад судлалын Семинарын анхны тэнхимийн эрхлэгч байлаа.

¹⁸ Бонн дахь Монгол судлалын эхлэлийн талаар Heissig(1968) бүтээлгээс үзнэ үү. Семинарын түүхийг Sagaster (2014) өгүүллэгээс үзнэ үү.

¹⁹ Хоёр дахь нь хожим Михаил Вайерст шилжсэн бөгөөд тэрбээр 1972 – 2003 онд Боннд Төв Азийн Хэл Соёл Судлалын тэнхимийг удирдсан профессорын хувьд сургалт явуулж байсан билээ.

сүүлчийн элч Хью Ричардсон, түрэг судлаач Аннемарий фон Габайн зэрэг нилээд олон алдартай эрдэмтэн, тэдний дотор монгол судлаачид Боннд зочин профессороор уригдан ажиллаж байсан билээ. Хэлний сургалтыг эх хэлтэн багш нар эрхлэн явуулж иржээ.



Зураг 6: хатагтайн хамт авахуулсан зурагт (1964 оны орчим) баруунаас зүүн тийш: ислам судлаач бөгөөд Дорно дахины Семинарын захирал доктор профессор Отто Шнийз (1901-1981), Колний Их Сургуулийн хятад, манж судлаач доктор профессор Вальтер Фукс (1902-1979), эртний хэл судлаач, Философийн факультетийн декан байсан доктор профессор Ханс Хертер (1899-1984), арын эгнээнд: хятад судлаач доктор профессор Петер Ольбрихт (1909-2001), хатагтай Ёоко Шигихара-Халтод, доктор профессор Вальтер Хайссиг (1913-2005), эм зүйч доктор профессор Вернер Шулеманн (1888-1975), тэдний арын эгнээнд: монгол хэлний багш Маттею Магадбүрин Халтод (1917-1978), хамгийн зүүн захад суугаа доктор профессор Теодор Клаузер (1894-1984), – христосын сүм хийдийн түүх судлаач, Бонны Их Сургуулийн ректор асан, Германы Эрдмийн Солилооны Албаны анхны ерөнхийлөгч

**Бонн дахь үйл ажил: Монгол судлалд Дорно-Өрнийн яриа
хэлцлийг дэмжин ажилласан нь**

Клаус Загастер 1969 онд шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалж, 1970 онд Эрдэмтэн Зөвлөх профессор цолыг хүртсэн байна. 1982 онд тэрээр Төв Азийн Хэл Соёл Судлалын тэнхмийн удирдлагын ажлыг хүлээн авч, 1989 оныг дуустал *Судалгааны Тусгай Салбар Дорно дахин, түүний дотор Төв Азийг онцлон судлах* (SFB 12) хэсгийн бүрэн эрхт төлөөлөгчийн үүргийг гүйцэтгэж байсан юм. Энэхүү судалгааны төсөлд Энэтхэг, Хятад судлалыг ч мөн хамааруулж байсан билээ.²⁰ Судалгааг олон янзын сэдэвчилсэн бүлгүүдэд хувааж, Клаус Загастер Төвдийн урлагийг судлах төслийг удирдан ажиллажээ. Вальтер Хайссигийн удирдан ажилласан “Туульс” хэмээх төслийн хүрээнд монгол ардын аман зохиолын соронзон хальсанд болон бичвэр хэлбэрээр буулгаж авсан цуглуулга бий болсон байна. Гэсэрийн туультай²¹ холбогдох материалыг нягтлан үзэж байхад Төвдийн соёл бүхий нутагт хамаарах газруудын хамгийн баруун хязгаар болох Умард Пакистаны Балтистаны талаарх материал маш хомс байгааг олж мэдсэн байна. Тиймээс Клаус Загастер тэнд 1980 оноос эхлэн хээрийн судалгааны ажил хийхэд бэлэн буй хүсэл сонирхлоо илтгэсэний учир нь 1989 онд Берлиний хана нурахаас өмнө БНМАУ, БНХАУ болон ЗСБНХУ-д нэвтрэн орох боломжгүй байсан билээ.

Гэвч Загастер арай өөр замаар анх удаа Монгол руу явжээ. 1973 онд (Германы) Залуу Христүүдийн Холбоо ЗХУ болон БНМАУ-руу эхний аяллаа зохион байгуулж, аяллын хөтөч хайж байв.²² Ийнхүү тэрбээр аялагчдын хамт Москвагаар дамжин нисэж Иркутск хүрээд тэндээсээ дамжин өнгөрөх Монголын төмөр замаар цааш явжээ. Ингэж аялагчдад хөтөч орчуулагчаар үйлчилж явахад нь Клаус Загастерт БНАГУ-д дунд сургуульд сурч, хожим оюутан байхдаа олж авсан орос хэлний мэдлэг нь ч ач тусаа өгч байжээ. Түүний хариуцсан бүлэгт арван долоогоос дал хүртэлх насны хорь орчим хүн багтаж явсан бөгөөд маш сайн бэлтгэлээ хангаж, орой бүр тодорхой сэдвээр илтгэл тавьж явсан Загастер энэ завшаан гарч ирэх хүртэл БНМАУ-руу очих боломж огт олдохгүй байсныг

²⁰ Вальтер Хайссиг 1969—1989 онд Германы Судалгааны Нийгэмлэгийн дэмжлэгтэйгээр SFB Судалгааны Тусгай Салбар хэмээх төслийн ажлыг удирдан хэрэгжүүлсэн юм.

²¹ Мөн Гэсэрийн туульс буюу Гэсэр хааны туульс (монголоор: Гэсэр хааны тууж) нэрээр алдаршсан, олон тооны хувилбартай, олон хэлээр түгсэн дуут найраглал нь Төв Азийн туульсийн хамгийн том нь юм.

²² Энэхүү санаачилга анх 1973 онд Дорно-Өрнийн зорчлийг намжаах зорилгоор Хелсинкид зохион байгуулагдсан Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны тухай бага хурлаар хэлэлцсэн сэдвүүдийн хүрээнд багтсан бололтой.

хүлээн зөвшөөрсөн юм. *Жуулчин* компани Монголын эртний нийслэл Хархорин хот, Говь-Алтай дахь Ёлын ам зэрэг олны танил очиж үзэх дуртай Монголын сонгодог газруудад хүрэх аяллын тээвэр зуучлалыг бүрэн зохион байгуулсан байсан учир зорьсон газартаа ирсэн хойно бүх зүйл асуудалгүй бүтжээ. Гэтэл адал явдал тэднийг өөр газар отож байжээ. Клаус Загастерыг монголд ирэхэд албаныхан түүнээс хариуцсан бүлгийнхнийхээ байх хугацааны зардал 12000\$ долларыг төлөхийг хүссэн байна. Уг зардлын төлбөрт авчирсан мөн хэмжээний чекийг тэд хүлээж авсангүй, Москва дахь консулын газарт визний хураамжинд хувь хүмүүс доллараар төлсөн хэмээн хэлээд ч нэмэр болсонгүй. Тиймээс Загастер Кассел хотын аяллын товчоо руу цахилгаан илгээж, Лондоны Банкин дахь *Жуулчин* компанийн дансанд нэхэгдэж буй мөнгийг тушаахыг шаардахаас өөр аргагүй болсон байна. Хэрэв төлбөр хийсэн баталгаа орж ирэхгүй бол өөрийг нь барьцаанд үлдээх ёстой хэмээн Загастерт анхааруулжээ. Гэвч тэрбээр 1970 оны эцсээр Олон улсын монгол судлаачдын Их хуралд оролцохоор дахин Монголд ирсэн учир тэрхүү анхааруулга бараг илүү ч байсан байж магадгүй юм.

Германы талцал хуваагдлын түүхэнд тулгарч байсан нийтлэг үзэгдлүүд шинжлэх ухааны салбарыг ч тойрч гараагүй нь 1959 оноос эхлэн таван жил тутам Улаанбаатарт зохион байгуулагддаг, олон улсын монгол судлаачдын мэдлэг туршлагаа солилцох хамгийн чухал талбар болсон энэхүү их хурлын сүүдэртэй талд ч харагджээ. Клаус Загастер Берлиний тэр үеийн Монгол судлалын салбарыг тэргүүлж байсан Ханс-Петер Фийтцетэй²³ Улаанбаатар зочид буудалд уулзаад, БНМАУ-руу арай гэж нэг орж ирэх боломж олдсонд хэрхэн баяртай буйгаа хэлсэнд цаадах нь бусдаас нилээд зайдуу очиж байгаад түүнд баяр хүргэсэн байна. Зүүн Европын монгол судлаачид Баруун Германаас ирсэн “ангийн дайсантай” ч эмээж цааргалахгүй ярилцаж байсан бол БНАГУ-ын зоригт эмэгтэй Эрика Таубегаас²⁴

²³ Ханс-Петер Фийтце (1939-2008) Монгол, Түрэг болон Алтай судлалаар суралцаж, БНМАУ-д дэд докторын зэрэг хамгаалжээ. Улмаар 1973 онд шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалж, 1976 оноос БНАГУ задран унасны дараах үеийг хүртэл Берлиний Хумболдтын Их Сургуулийн Монгол судлалыг хариуцсан профессороор ажиллаж байсан. Ийнхүү 1990-ээд оноос эхлэн түүний оронд хүн ажиллаагүй бөгөөд Берлиний Монгол судлал өдийг хүртэл орон тооны профессоргүй ажиллаж байгаа билээ.

²⁴ Эрика Таубе (*1933) 1952 оноос эхлэн Лайпциг болон Бээжинд Хятад ба Төвд судлалаар суралцаж төгсөөд Лайпцигийн Зүүн Ази судлалын Институтэд эрдэм шинжилгээний ажилтан байхдаа Монгол судлалыг бие даан судалсан байна. 1964 онд монгол үлгэрүүдийн тухай сэдвээр дэд эрдэмтний зэрэг хамгаалж, 1966 оноос судалгааныхаа чиглэлийг Алтайн тувачуудыг судлах ажилд хандуулан, тэдний хэлийг ч мөн зааж байсан юм. Дээр дурьдсан бага хурлын үеэр тэрээр Баруун Германы монгол судлаачидтай нийтийн өмнө ил холбоо тогтоосон нь өөрт нь маш их сөрөг нөлөөллийг үзүүлсэн билээ. Тэрбээр 1992 оноос эхлэн 1998 онд гавьяаныхаа амралтанд суух хүртлээ Лайпцигийн Төв Ази ба Энэтхэг судлалын Институтэд эрдэм шинжилгээний ажилтан байлаа.

бусад эрдэмтэн судлаачид бүгдээрээ дөлж зайлсхийн хондий харьцаж байжээ. Эрика Таубе, түүний нөхөр Манфред Таубе²⁵ болон Паул Рачневски нартай Клаус Загастер хоёр германыг заагласан хил хязгаарыг даван захидлаар харилцдаг байсан байна.

1970-аад оны дундуур түүнд зөвлөлтийн монгол судлаач нөхрийнхөө урилгаар Сибирийн монгол төв болох Улаан-Үд рүү аялах зөвшөөрөл олдсон байна. Театрт үзвэр үзэж байгаад завсарлагааны үеэр мэргэжил нэгт буриад нөхөр нь түүнээс тухайн үеийн Баруун Германы Атом Цөмийн Энергийн асуудал хариуцсан бөгөөдхожим Батлан Хамгаалахын сайд асан Франц Ёозеф Штраусын талаар ямар бодолтой байдгийг нь сонирхжээ. 1975 онд Штраусын Хятадад айлчлан Мао Зэдонгтэй хийсэн уулзалтын тухай бодоод: “Энэ хүн бол одоогоор манай тэргүүлэх хятад судлаач мөн” хэмээн нүдээ ирмэн хэлжээ. Гэтэл мэргэжил нэгт найз нөхдийн хоорондын санал нийлсэн энэ ярианд дахиад л хүйтэн дайны сүүдэр туссан байна. Владивосток руу аялж явсан Москвагийн радиогийн герман хэлний хэлтсийн дарга, Клаус Загастерыг Зөвлөлтийн Бүгд Найрамдах Буриадын Автономит Улсын нийслэлд түр саатаж буйг мэдэж байсан учир түүнээс сурвалжлага авах хүсэлтээ илэрхийлжээ. Орос, Буриад улсын харилцааны талаар ямар бодолтой байдаг тухай сэтгүүлчийн төвөгтэй асуултанд Загастер дипломат ухаан сийлгэн: хүрэлцэн ирээд тун удаагүй байгаа учир энэ талаар сайн мэдэхгүй байна хэмээн хариулсан байна. Гэвч энэ сурвалжлагын үр уршиг удалгүй гарсан нь: Клаус Загастер томилолтынхоо тайланг уламжлал ёсоор Москва дахь ХБНГУын ЭСЯ-нд тавьж байтал соёлын дэд атташе түүнийг ирэхээсээ өмнө ЭСЯ-наас зөвшөөрөл авах ёстой байсан хэмээн буруутгажээ. Түр байх хугацаандаа буриад монгол эх хэлтнээс бичлэг хийж цуглуулах бодолтой байсныг ч албан ёсоор зөвшөөрөөгүй зэргийг өнөөдрийн өнцгөөс төсөөлөх амаргүй билээ. Тиймээс хэл шинжээч Ц.Б.Будаев буриад эх хэлтнээс соронзон хальсанд буулгасан багахан бичлэгийг түүнд нууцаар өгч байсан байна.²⁶

Загастер 1975 онд Индиана мужийн Блүмингтонд зохион байгуулагдсан *Олон Улсын Алтай Судлалын Байнгын Бага Хурлын* (цаашид PIAC гэх) 18-р чуулганд оролцсоны дараа энэхүү анхны завшаанаа ашиглан халимагуудтай дахин уулзсан

²⁵ Манфред Таубе (*1928) Лайпцигт Энэтхэг, Төвд болон Монгол судлалаар суралцаж, 1957 онд дэд докторын, 1965 онд шинжлэх ухааны докторын зэрэг тус тус хамгаалжээ. 1966 онд тэрээр төвд ба монгол хэл шинжлэлийн багшаар уригдан ажилласан байна. 1992-1995 онд Төвд, Монгол судлалын профессороор ажиллаж байсан билээ.

²⁶ Дөнгөж 1989 онд Гласность, Перестройкагийн эерэг нөлөөгөөр, Улаан-Үдэд “Монгол хэлтэн ард түмнүүдийн уран зохиолын” тухай бага хурал зохион байгуулагдсан нь олон соёл хамарсан олон үндэстэн дамнасан асуудлыг зориуд хөндөн хэлэлцсэн цуглаан болсон байна.

нь дэлхийн хоёрдугаар дайны дараа АНУ-руу дүрвэн гарсан бүлэг хүмүүсийн төлөөлөл байжээ. Тэрээр энэ үеэр болсон ярилцлага бусад үйл явдлаас түүвэрлэн авч боловсруулан, хожим бүлгийн ижилсэл ба шашны тухай бичсэн өгүүлэлдээ²⁷ оруулсан юм. Загастерт Халимаг руу өөрийн биеэр очих боломж дөнгөж 1990 онд л Жангарын тууль судлалаар Элистад зохион байгуулагдсан бага хуралд оролцох далимаар олдсон байна. Тэрбээр 1977 онд Хятад руу анх удаа аялахад соёлын хувьсгалын үр дагавар тодорхой мэдрэгдсэн хэвээр байсан цаг үе байжээ. Хожим нь Амдо болон Өвөр Монголын Өөртөө Засах Оронд нилээд хэдэн удаа аялан очих завшаан тохиож байсан юм.

1982 онд Вальтер Хайсигийг гавьяаныхаа амралтанд суусны дараа Клаус Загастерыг Төв Азийн Хэл Соёл Судлалын Салбарыг удирдах С4 зэргийн профессороор урин ажиллуулжээ. Мөн тэр онд тэрбээр Далай Ламыг анх удаа Бонны Семинарт урин залж, улмаар 1986 онд дээрхийн Гэгээнтэн дахин ирсэн билээ. Клаус Загастер БНМАУ-ын мэргэжил нэгт нөхдөө ч Боннд тогтмол урьж авчирч байсны дотор 1985 онд Монгол судлалын гарамгай хоёр эрдэмтэн Цэндийн Дамдинсүрэн, Далантайн Цэрэнсодном нар хүрэлцэн ирсэн байна.



Зураг 7: зүүн гараас Д.Цэрэнсодном, Ц.Дамдинсүрэн, К.Загастер нар 1985 онд Бонн дахь Драхенфелс буюу Лууны хадны дэргэд

²⁷ Sagaster (1999).

Анх удаа дахин БНАГУ-руу очих зөвшөөрөл Клаус Загастерт дөнгөж 1988 онд л Олон Улсын Алтай Судлалын Байнгын Бага Хурал (PIAC) Ваймар хотод зохион байгуулагдахад олдсон байна. Учир нь Зүүн Герман дахь мэргэжил нэгт нөхөр, тухайн үедээ аяллын кадр буюу боловсон хүчин хэмээн нэрлэгдэн Баруун Герман руу нилээд хэдэн удаа ирж очих зөвшөөрөлтэй байсан Ханс-Петер Фийтце түүнийг урьжээ. Гэтэл PIAC-т ч мөн адил үзэл сурталжсан удирдамж зааварчилгаа хар сүүдрээ тусгасан байна: Загастерыг (БНХАУ-ын Өвөр Монголын Ордосын нутагт байх) Эзэн Хороонд (Ejen Qoroγa) хийдэг Чингис Хааны Тахилгын тухай илтгэл тавьж байхад БНМАУ-аас ирж оролцсон утга зохиол судлаач П.Хорлоо түүнээс юу бодож ард түмнүүдийн алуурчны тухай илтгэл тавих болов хэмээн бухимдан асууж байжээ.

Гэвч хүйтэн дайны иймэрхүү давалгаа удалгүй арилсан нь – 1989 оны 11-р сард Берлиний Хана нуран унасны дараа 1990 онд Клаус Загастер энэхүү боломжийг шүүрэн авч Хумболдтын Их Сургуулийн Монгол судлалын салбарт зочлон очжээ. Мэргэжил нэгт монгол судлаач Үта Шөне (*1941) болон тухайн үед Берлинд зочин судлаачаар ажиллаж байсан Шаравын Чоймаа (*1951) нартай ярилцаж суухад түүнд судалгааны ажлыг хувааж хийх дараах саналыг тавьсан байна. Бонн дахь Монгол судлал өдийг хүртэл гол анхаарлаа чиглүүлж ирсэн түүх-хэл шинжлэлийн сэдвүүдийг цаашдаа ч үргэлжлүүлэн түлхүү судалж, харин Берлинд голчлон орчин цагийн Монгол улсад анхаарлаа хандуулах нь зүйтэй хэмээжээ. Гэвч Загастер энэ саналыг нэг л бүрэн дүүрэн сайшаан хүлээж авч чадсангүй, учир нь хэдийгээр Берлин, Бонн хоорондоо зайтай оршдог ч энэ нь харин ч хоёр газартаа хоёулаа Монгол судлалыг бүрэн хэмжээгээр нь төлөөлөн хөгжүүлэх нь зүйтэй болохыг харуулж байгаа бус уу гэж бодсон байна.

1993-1996 оныг дуустал Клаус Загастер Көлн дэх Дорнын судлал болон Олон Улс Судлалын Холбооны Институтын Эрмийн Зөвлөлийн гишүүн, 1994-2003 онд Гөттинген²⁸ дэх *Societas Uralo-Altaica* буюу Урал-Алтай Судлалын Нийгэмлэгийн гүйцэтгэх захирал (тэрбээр 2006 оноос эхлэн хүндэт гишүүн нь болсон), мөн 1995 оноос Дюсселдорф дахь Нордрайн-Вестфален мужийн ШУА-ийн жинхэнэ гишүүн юм. Энэ академиас тэрээр Вальтер Хайссиг, Рюдигер Шотт²⁹ нарын үүсгэн

²⁸ 1998 оноос эхлэн буюу гавьяаныхаа амралтанд сууснаасаа хойш Загастер Гөттингений Их Сургуульд олон семестрийн турш уйгаржин монгол бичиг зааж байсан юм.

²⁹ Рюдигер Шотт (1927-2012) угсаатны зүй, газарзүй, түүх, гүн ухаан, сэтгэл судлал болон харьцуулсан шашин судлалаар суралцан, Бонны Их Сургуульд дэд докторын зэрэг хамгаалаад, хожим нь Философийн Факультетэд сургалт явуулах эрхээ олж авсан байна. 1964 оноос гавьяаныхаа амралтанд суух хүртлээ тэрбээр Мюнстерт ажиллаж, дараа нь Бонны Угсаатны Судлалын Институтэд багшлан, илтгэл тавьж байлаа.

байгуулсан Олон Улсын Соронзон Хальсны Архивт буй Хайссигийн цуглуулсан монгол ардын аман зохиолын бичлэгүүдийг анхаарч цэгцлэх ажлыг хүлээн авсан байна. Тэрхүү цуглуулгын ихэнх хэсэг болох зүүн Монголын хийлийн дуунууд хэмээн нэрлэгддэг (хятадын ардын романуудын монгол хувилбарууд), түүнчлэн туульс болон бөөгийн дуудлага зэрэгматериалуудыг судлан боловсруулах ажлыг италийн монгол судлаач Элизабета Киодо³⁰ эхлээд хэдэн жил болж байгаа билээ. Клаус Загастер гавьяаныхаа амралтанд суухаас нэг жилийн өмнө буюу 1997 онд Хөх хот дахь Өвөр Монголын Их Сургуулийн хүндэт профессор болсон байна.

Улаанбаатараас баруун тийш 300 км зайтай орших Харбухын Балгасаас 1970 онд монгол-зөвлөлтийн экспедицийнхний нээж илрүүлсэн монгол, төвд хэлээрх бичмэл материалуудын археологийн олдворуудыг судлан боловсруулах ажлыг тэрбээр 1993-2003 онд удирдан гүйцэтгэж байлаа. Хусны үйсэн дээр бичсэн 1400 гаруй бүтэн болон тасархай хуудас бүхий тэдгээр олон төрлийн бичвэрүүд 17-р зууны эхний хагаст хамаарагдах бөгөөд өдийг хүртэл уламжлагдан ирсэн монгол сурвалж бичгийн хамгийн эрт үеийнхэд тооцогдож байгаа билээ. Монгол улсын ШУА-аас эдгээр бичвэрийг Бонны Төв Азийн Семинарт хүлээлгэн өгөхдөө сэргээн засварлах болон хэл шинжлэлийн талаас нь судлан боловсруулах хүсэлт тавьсан байна. Уг материалыг судлан боловсруулах ажлыг Италийн монгол судлаач Элизабета Киодо эрхлэн гүйцэтгэжээ.³¹ Энэ ажлын үр дүн болох сэргээн засварлаад, шинжлэн судалж, зохих ёсоор хадгалсан бичвэрүүдийг 2012 онд Монгол Улсын Номын Санд хүлээлгэн өгсөн байна.

2006 онд Улаанбаатарт болсон Олон Улсын Монгол Судлалын IX хурлаас Клаус Загастерыг Олон Улсын Монгол Судлалын Холбооны (IAMS) ерөнхийлөгчөөр сонгосон бөгөөд 2008 онд түүнийг Бухарестэд PIAC-ын шагналаар шагнажээ.

Улмаар 2012 онд Клаус Загастер Бонны Монгол судлалыг хаагдахаас авран хамгаалсан юм. Учир нь 2009 онд Монгол судлалын профессор Вероника Файт гавьяаныхаа амралтанд сууж, түүний оронд 2010 оноос ажиллаж эхэлсэн Бээжингийн Их Сургуулийн профессор Боржигидай Оюунбилиг ганцхан жилийн дараа буцсан бөгөөд 2011 онд Монгол судлалын салбар Бонны Их Сургуулийн хөрөнгө хэмнэх албан шахалтын золиос болоод байсан билээ. 2012 онд Монгол Улсын ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж ХБНГУ-д төрийн айлчлал хийх үеэр

³⁰ Өдийг хүртэл үргэлжилсээр байгаа энэхүү судалгааны төсөлт ажлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Sagaster (2016) өгүүлэгээс авна уу.

³¹ Үр дүн нь хожим UNESCO-гоос хүлээн зөвшөөрөгдсөн энэхүү төсөлт ажлын хоёр ботийг хатагтай доктор Киодо 2000, 2009 онд тус тус хэвлүүлсэн билээ.

Загастер хоёр Герман улс нэгдсэний дараа үлдсэн Монгол судлалын цорын ганц бие даасан профессорын орон тоог устгах гэж буйг Монголтой сайн холбоотой байдгаа ашиглан өндөр төвшний энэ зочны сонорт хүргэжээ. Ерөнхийлөгч Элбэгдорж Бонны Их Сургуулийн Монгол судлалын профессорын санхүүжилтийн хагасыг Монгол Улс арван жилийн хугацаагаар хариуцахад бэлэн буйгаа³² илэрхийлсэн байна. Энэ тухай Загастер өөрөө хэлэхдээ:

“Ийм нөхцөлд Бонны Их Сургуулийн ректорат болон Философийн Факультет санхүүжилтийн үлдсэн хагасыг хариуцахад бэлэн гэдгээ илтгэсэн юм. Энэ шийдвэрийг гаргахад Германы Эрдэмтэн Солилцооны Алба буюу DAAD тухайн мэргэжлийн салбарт зайлшгүй шаардлагатай орчин цагийн монгол хэл заах багшийг цалинжуулах, ингэснээр Монгол судлалыг “жижиг салбар”-ынх нь хувьд дэмжихээ илэрхийлсэн нь чухал түлхэц болсон билээ. Ингэж Монгол судлал аврагдсан юм.”³³

Энэ үйл явц ид шид мэт боловч энэ нь судалгаа шинжилгээний болон их дээд боловсролын салбар дахь Клаус Загастерын нэр хүнд, дипломат эв дүй, ур ухаан тодийгүй хүйтэн дайны хамгийн холдүү цаг үед ч ард түмэн соёл хоорондын ойлголцол, эрдэмтэн судлаачид харилцан санал бодлоо солилцон ажилладаг байхын толоо үр бүтээлтэй яриа хэлцэл өрнүүлж, сэтгэл зүтгэл, мэдлэг туршлагаа зориулж ирсний ач тус мөн.

³² Энэхүү гэрээг 2014 онд байгуулсан бөгөөд дэлгэрэнгүйг Бонны Их Сургуулийн мэдээллийн хуудасны тайлан мэдээнээс харна уу: <https://www.uni-bonn.de/neues/275-2014/>.

³³ Sagaster, 2014, 8-р талд.



Зураг 8: Клаус Загастер 2015 оны 4-р сард Бонн хотноо зохион байгуулагдсан “Монгол судлал – эрдэм шинжилгээ, дээд боловсролын салбарын хамтын ажиллагааны хэтийн төлөв” сэдэвт олон улсын бага хуралд илтгэл тавьж буй нь, Foto: briti bay.

Abstract: Klaus Sagaster is appreciated as one of the most distinguished Mongolists and Tibetologists of today, especially as the spectrum of his oeuvre goes far beyond these two Asian Studies disciplines. His interest in religion started from early youth and resulted in studying five Asian and five European languages. This enabled him to not only analyse relations between religion and politics from different perspectives but also to engage with cross-disciplinary research areas such as symbolism, historiography, literature and the intercultural transfer of motifs with an advanced methodological pluralism. Equally remarkable for his generation, which was born into the darkest chapter of German history, is that Sagaster has never been sitting in the ivory tower, but connected his studies and research with contemporary humanistic concerns and advocated for rapprochement across the Iron Curtain during the frosty times of the Cold War. This article focuses on biographical background episodes of Sagaster's academic career, which are not publicly known. During his life he witnessed radical societal changes along with different political systems and managed to keep his head above the waves of the turbulent German political history. Despite personal experiences with political repression, Sagaster did not act dogmatically but behaved with integrity and facilitated, also during

his journeys into countries of the former Eastern bloc, international cooperation at eye level based on mutual respect. With this thoughtful approach and wise attitude he has contributed to surmounting the Cold War in Mongolian studies more than anyone else. It is particularly thanks to his academic reputation, but also to his considerateness, prudence and diplomatic skilfulness that the only remaining professorship in Mongolian Studies in Germany continues to exist. Now an emeritus professor, Sagaster remains to be a highly valued academic advisor and influential consultant, still facilitating contacts and communication across borders.

Номзүй

1. Barkmann, Udo B.: Erinnerungen an den Nestor der ostdeutschen Mongolistik Paul Ratchnewsky. In: *asien, afrika, lateinamerika* 1994 (22) Nr. 6, S. 595-617.
Баркманн, Удо Б.: Зүүн Германы Монгол судлалын хамгийн ахмад үеийн төлөөлөл Паул Рачневскиг дурсан санахад.
2. Heissig, Walther (1968): *Mongolistik an deutschen Universitäten*. Wiesbaden.
Хайссиг, Вальтер (Heissig, Walther) (1968): Германы их сургуулиудын монгол судлал.
3. Hoffmann, Joachim (1974): *Deutsche und Kalmyken [sic] 1942 bis 1945. Einzelschriften zur militärischen Geschichte des Zweiten Weltkrieges Bd. 14.* Freiburg: Rombach.
Хоффмани, Ёоахим (Hoffmann, Joachim) (1974): Германууд ба Халимагууд 1942 – 1945 онд. Дэлхийн хоёрдугаар дайны цэргийн түүхэнд холбогдох салангид бичвэрүүд 14-р боть. Фрайбург: Ромбах.
4. Kollmar-Paulenz, Karénina und Christian Peter (Hrsg.): *Tractata Tibetica et Mongolica: Festschrift für Klaus Sagaster zum 65. Geburtstag (Asiatische Forschungen)*. Wiesbaden: Harrassowitz 2002.
Коллмар-Пауленц, Каренина ба Кристиан Петер: Клаус Загастерын 65 насны ойд зориулсан эмхэтгэл
5. Kollmar-Paulenz, Karénina; Eimer, Helmut: Klaus Sagaster – Bibliography. In: Shen Weirong (Ed.): *Historical and Philological Studies of China's Western Regions*. Beijing: Science Press 2013: 1-15
Коллмар-Пауленц, Каренина, Аймер, Хелмут: Клаус Загастер – Номзүй. Kollmar-
6. Sagaster, Klaus (1999), "Religion and Group Identity in Present Mongolia," in *Dissociation and Appropriation Responses to Globalization in Asia and Africa*,

ed. Katja Füllberg-Stolberg et al. Berlin: Das Arabische Buch: 185-193.

Загастер, Клаус (1999), "Өнөөгийн Монгол дахь шашин ба бүлгийн ижилсэл".

7. Sagaster, Klaus: Chinggis der Unsterbliche. Zur Wirkungsgeschichte Chinggis Khans. In: Dschingis Khan und seine Erben. Das Weltreich der Mongolen. Katalogbuch zur Ausstellung. 2005. Hrsg. Kunst- und Ausstellungshalle der Bundesrepublik Deutschland Bonn. Hirmer Verlag, S. 18-29
Загастер, Клаус: Үхэшгүй монх Чингис. Чингис хааны үйл хэргийн түүх. Чингис хаан ба түүний өв сан. Монголчуудын дэлхийн эзэнт гүрэн. Үзэсгэлэнгийн каталог ном.
8. Sagaster, Klaus (2014): Die Mongolistik und Zentralasienwissenschaft in Bonn. Ein Beitrag zum 50-jährigen Jubiläum. In: *Mongolische Notizen. Mitteilungen der Deutsch-Mongolischen Gesellschaft* (22), S. 3-8.
Загастер, Клаус: Бонны Монгол ба Төв Ази судлал. 50 жилийн ойд зориулсан өгүүллэг.
9. Sagaster, Klaus (2016): Die Walther-Heissig-Sammlung mongolischer Volksliteratur in Düsseldorf. In: *Mongolische Notizen. Mitteilungen der Deutsch-Mongolischen Gesellschaft* (24), S. 3-9.
Загастер, Клаус: Дюсселдорфт хадгалагдаж буй Хайссигийн монгол ардын уран зохиолын цуглуулг.
10. Tennstedt, Florian: „Wohltat und Interesse. Das Winterhilfswerk des Deutschen Volkes. Die Weimarer Vorgeschichte und ihre Instrumentalisierung durch das NS-Regime.“ In: *Geschichte und Gesellschaft* 13(1987), S. 157–180.
Теннштедт, Флориан: "Сайн үйл ба сонирхол. Германы ард түмний өвөлд туслах үйл хэрэг. Ваймарын омнох түүх болон түүнийг нацист дэглэмийнхэн арга хэрэгслээ болгон ашигласан нь." Түүх ба нийгэм 13.
11. Veremej, Nellja (2004): Eine Karawanserei unter dem Hakenkreuz. In: *Der Freitag* (09.01.2004); Веремей, Нелля: *Жинчдийн буудал хас тэмдгийн дор. Баасан гараг* online: <https://www.freitag.de/autoren/der-freitag/eine-karawanserei>.
12. Vietze, Hans-Peter (1988): Wörterbuch Mongolisch-Deutsch. Leipzig: Verlag Enzyklopädie.
Фийтце, Ханс-Петер - Vietze, Hans-Peter (1988): Монгол – Герман толь.

13. Walravens, Hartmut (Hrsg.) (2012): Walther Heissig (1913–2005). Mongolist, Zentralasienwissenschaftler, Literaturwissenschaftler und Folklorist. Leben und Werk. Würdigungen, Dokumente, Forschungsberichte und Rundfunkprogramme auf Audio-CD. Wiesbaden: Harrassowitz.

Валравенс, Хартмут (2012): Вальтер Хайсиг (1913–2005). Монгол судлаач, Төв Ази судлаач, уран зохиол судлаач, аман зохиол судлаач. Амьдрал, бүтээл. Хүндэтгэлийн бичвэрүүд, баримт материалууд, судалгааны тайлан илтгэлүүд болон радио програмууд (аудио-CD-д буулгасан).

Герман хэлнээс орчуулсан: Др. Сэндэржавын АЛИМАА
(Герман, Монгол судлал)